

Российская академия наук
Институт восточных рукописей
(Азиатский Музей)



Адрес учредителя: 191186,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.
Адрес редакции: 191186,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.
Адрес издателя: 191186,
Санкт-Петербург, д. 18.
Тел.: +7 (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

Регистрационный номер
свидетельства о регистрации
средства массовой информации
ПИ No ФС77-79202
от 22 сентября 2020 г.

MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведческих исследований

Том XXVI • 2023 • № 2

Выходит 4 раза в год

Издается с 1986 г.

Учредитель: ФГБУН

Институт восточных рукописей РАН

Посвящается 80-летию со дня рождения монголоведа
Алексея Георгиевича Сазыкина (1943–2005)

Редакционная коллегия:

И. В. Кульганек, *главный редактор, доктор филологических наук (Россия)*
Д. А. Носов, *секретарь редколлегии, кандидат филологических наук (Россия)*
М. А. Козинцев, *помощник секретаря (Россия)*
Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*
А. Бирталан, *доктор наук (Венгрия)*
Р. М. Валеев, *доктор исторических наук (Россия)*
Л. С. Дампилова, *доктор филологических наук (Россия)*
И. В. Зайцев, *доктор исторических наук, профессор РАН (Россия)*
Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*
В. Капишовска, *доктор наук (Чехия)*
Э. Мунхцэцэг, *кандидат филологических наук (Монголия)*
С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*
К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*
М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*
Р. Поп, *доктор наук (Румыния)*
Ц. Саранцацрал, *доктор филологических наук (Монголия)*
Т. Д. Скрынникова, *доктор исторических наук, профессор (Россия)*
С. Чулуун, *академик МАН (Монголия)*
Е. Э. Хабунцова, *доктор филологических наук (Россия)*
Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*
Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*

Оригинал-макет – М. В. Алексеева

Литературные редакторы и корректоры – Д. А. Носов, И. В. Кульганек

Технический редактор – М. А. Козинцев

Подписано в печать 15.06.2023

Формат 60×90 1/8. Объем 10 печ. л. Заказ №

Тираж 300 экз.

Отпечатано в типографии ООО «Свое издательство»,

Адрес типографии: 191040. Санкт-Петербург. Пушкинская ул., 4.

e-mail: editor@isvovoe.ru

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/veuk-bk2e-gk5p

12+

© Институт восточных рукописей РАН
(Азиатский Музей), 2023

© Коллектив авторов, 2023

В НОМЕРЕ:

К. В. Орлова. А. Г. Сазыкин (1943–2005) в российском монголоведении (к 80-летию со дня рождения)	5
---	---

ИСТОРИЯ. ИСТОРИОГРАФИЯ. ИСТОЧНИКОВЕДЕНИЕ

И. В. Захарова, М. В. Мандрик. О подготовке частной торгово-промышленной и ученой экспедиции братьев Бутиных в Китай в 1870 г.	11
Т. И. Юсупова. Монголия в фотографиях (конец XIX – первая треть XX в.): опыт визуализации истории страны.....	19

ФИЛОЛОГИЯ

Б. Б. Горяева. Жанр калмыцкого фольклора <i>яс кемэлһн</i> (по материалам архива И. И. Попова).....	29
Бямбажав Баяржаргал. Исследование случаев соответствия «последлог-последлог» на разных временных срезах монгольского языка (на материале текстов XIII, XVII и XX вв.) ..	37
М. П. Петрова. Знаки и символы визуальной поэзии Риммы Ханиновой.....	42
Рагчаа Бигэрмаа. Ардын уран зохиолч Б. Лхагвасүрэнгийн шүлэг дэх ардын аман зохиолын уламжлал ("Үлгэр нөмрөгөн хэвнэг" шүлгийн жишээр) (Фольклорные традиции поэзии народного писателя Б. Лхагвасурэна (на примере стихотворения «Бурка, окутанная сказкой»)	52
Б. Л. Тушинов. Чахар-геше Лосанг Цултим (1740–1810): «Сердце намтара» Дже Цонкапы.....	59
В. З. Церенов. Исторические реалии сказки «Мудрая невестка» (кереитское предание)	69
Н. В. Ямпольская. О формировании ойратских версий одного <i>санга</i> Белого Старца	76

РЕЦЕНЗИИ

Т. Д. Скрынникова. Рец. на книгу: А. К. Салмин. Академические исследования этнической самобытности чувашского народа. СПб.: Нестор-История, 2022. 332 с. ISBN 978-5-4469-1994-9	92
---	----

IN MEMORIAM

Эрдэнийн Пурэвжав (1961–2023).....	96
------------------------------------	----

**АРДЫН УРАН ЗОХИОЛЧ Б. ЛХАГВАСҮРЭНГИЙН ШҮЛЭГ
ДЭХ АРДЫН АМАН ЗОХИОЛЫН УЛАМЖЛАЛ
(«Үлгэр нөмрөгсөн хэвнэг» шүлгийн жишээгээр)
(Фольклорные традиции поэзии народного писателя
Б. Лхагвасурэна (на примере стихотворения
«Бурка, окутанная сказкой»))**

Одной из наиболее важных духовных ценностей монгольского народа является фольклор. До нашего времени дошло огромное количество народных песен, сказок, легенд, игр. Народный писатель Б. Лхагвасурэн занимает ведущее место в развитии современной монгольской литературы. Им написано несколько детских стихов с использованием фольклорных мотивов.

В данной статье анализируется стихотворение «Бурка, окутанная сказкой», делается попытка раскрыть художественные особенности произведения, в котором отражены уникальные черты менталитета, культуры, традиционного мышления, принципов морали монголов. В статье проводится аналогия поведенческих мотиваций современных героев с базовыми установками действий персонажей монгольского фольклора. Статья затрагивает проблемы традиции и новаторства современной монгольской поэзии, ментальные связи поэта XX века с поэзией древнейших времен. Уделяется внимание жанру монгольской сказки, понимаемому автором статьи как тип устной литературы, целью которой является иллюстрация примера, выражаемого с помощью условного изображения реальной действительности, чаяний народа. В статье делается попытка понять новаторские художественные методы и приемы, используемые Б. Лхагвасурэном для привлечения сказочного материала в свои произведения.

Ключевые слова: монгольский фольклор, сказки, традиции, новаторство, поэзия.

Об авторе: Рагчаа Бигэрмаа, Ph.D., старший преподаватель, кафедра Азиатских исследований, Школа иностранных языков, Университет науки и техники (Монголия, Улан-Батор) (bigermaa@must.edu.mn). ORCID 0000-0003-2033-5441.

© ИВР РАН, 2023

© Бигэрмаа Р., 2023

УДИРТГАЛ

Монголчуудын оюуны соёлын үнэт зүйлийн нэг нь монгол ардын аман зохиол билээ. Ийм ч учраас ардын аман зохиолын домог үлгэр, тоглоом наадмын аман зохиол гэх мэт олон төрөл зүйл үеэс үед улам боловсронгуй болж, эдүгээ бидэнд уламжлагдан иржээ. Ардын аман зохиол, орчин үеийн уран зохиол нь уламжлал шинэчлэлийн нягт уялдаа холбоотой хөгжиж ирсэн юм. Тухайлбал, монголын орчин үеийн уран зохиолын нэг төрөл болох яруу найргийн хөгжилд Ардын уран зохиолч Б. Лхагвасурэн өөрийн уран бүтээлээр шинэчлэл хийж, голлох

байрыг эзэлдэг. Тэрээр ардын аман зохиолоос сэдэвлэн хүүхдэд зориулсан зарим шүлгээ бичсэн байдаг. Жишээ нь, “Үлгэр нөмрөгсөн хэвнэг”, “Хорголон бөөдий” гэх мэт. Бид энэ өгүүллээрээ “Үлгэр нөмрөгсөн хэвнэг” шүлгийг нь сонгон авч, монгол ардын аман зохиолын уламжлал, шинэчлэлийн холбоо, монгол соёл, зан заншлын онцлогийг тодруулан, олон нийтэд таниулах, цахим орчинд түгээх, зохиолчийн уран чадварын онцлогийг илрүүлэхийг зорив.

Энэ зорилгодоо хүрэхийн тулд онол, практикийн судалгаа хийж, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, ажиглах зэрэг судалгааны аргуудыг хэрэглэсэн болно.

ҮНДСЭН ХЭСЭГ

Эдүгээ дэлхийд шинжлэх ухаан, техник технологи үсрэнгүй хөгжин, мэдээллийн хурд нэмэгдэхийн хэрээр улс үндэстнүүдийн соёл, зан заншил харилцан нөлөөлж, даяаршиж байна. Иймд энэ зууныг бид “Мэдээллийн эрин зуун” хэмээн нэрлэдэг. Дэлхий нийтээр даяаршиж, соёлын солилцоо эрчимжсэн энэ үед аливаа улс үндэстэн тусгаар тогтнол, соёл, хэл, зан заншил, уламжлалаа хадгалж хамгаалах, хөгжүүлэхийн тулд хичээн ажиллаж байна.

Бид энэхүү өгүүлэлдээ монголчуудын сэтгэлгээний өвөрмөц онцлогийг нээн харуулсан ардын аман зохиолын зарим төрөл зүйлийг яруу найрагч Б. Лхагвасүрэн өөрийн уран бүтээлд хэрхэн тусгасан, мөн домог үлгэрийн өгүүлэмж орчин үеийн яруу найрагт хэрхэн илэрч буй, монгол соёл, монгол багачуудын сэтгэлгээний өвөрмөц онцлог, тоглоом наадмын аман зохиолын тухай өгүүлнэ.

Нөгөө талаас, монголчуудын уламжлалт сэтгэлгээний онцлог болох ардын аман зохиол, сургаал, үлгэр өгүүллэгээр сурган хүмүүжүүлэх онцлог, түүнийг уламжлан хөгжүүлэх, амьдралтай холбон тайлбарлаж, хэрэглэх асуудлыг хөндсөнд тус өгүүллийн үнэ цэн, шинэлэг тал оршино.


Үлгэр нь монгол ардын аман зохиолын эртний төрөл зүйлийн нэг юм. Нийгмийн бодит байдал, ард олны хүсэл мөрөөдлийг илэрхийлсэн болзолт уран сэтгэмжийг ашиглан, сургах, үлгэр жишээ үзүүлэх аман зохиолын төрөл зүйлийг үлгэр [Галбаатар, 2012. Х. 441] гэнэ.

Үлгэрт үнэн байдлыг хэтрүүлж, амьтайг амьгүйшүүлж, амьгүйг амьшуулах зэргээр уран яруу дүрслэлийг хэрэглэн, ер бусын сонин

хачин үйл явдал, дүр дүрслэл, далд ёгт санааг илэрхийлдэг. Үлгэрийг өгүүлэмж, хэв шинж, сэдвээр нь аж байдал, адал явдал, шидэт үлгэр, адгуусан амьтны үлгэр гэх мэтээр ангилдаг.

Уран зохиолд ардын аман зохиолын энэ төрлөөс сэдэвлэн, өвөрмөцөөр зохиомжилсон бүтээлүүд цөөнгүй байдаг. Тухайлбал, Л. Бадарч “Салан баавгайн үлгэр”, А. С. Пушкин “Алтан загасны үлгэр” гэх мэт. Мөн Ардын уран зохиолч Б. Лхагвасүрэнгийн “Үлгэр нөмрөгсөн хэвнэг” [Лхагвасүрэн, 2006. Х. 147] шүлгийг нэрлэж болно. Тэрээр энэхүү шүлгээ XIII зууны үеийн Саж Бандида Гунгаажалцан¹ (1182–1251)-гийн төвөд хэлээр зохиож, монгол хэлнээ сүүлд хөрвүүлэгдсэн “Эрдэнийн сан Субашид” үлгэрийн цоморлигийн 3 дугаар бүлэг болох “Муу тэнэгүүдийг танихын аймаг”-ийн нэгэн шүлэг “Талуу ба мэлхийн үлгэр” [Лхагвасүрэн, 2006. Х. 84] -ээс сэдэвлэн бичжээ. Дээрх номын бүрэн нэр нь санскритаар “Субашид радна ниди”, төвөдөөр རྒྱལ་ཁབ་འགྲུབ་པའི་རྒྱལ་ཁབ་ཆེན་པོ་ཞེས་པའི་རྒྱལ་ཁབ་ཆེན་པོ་ “Лэгшад ринбочей дэр”, монголоор “Сайн үгт эрдэнийн сан” гэсэн үг бөгөөд Монголд “Субашид” гэж товчилсон нэрээр, Төвөдөд “Сажа лэгшад” гэж алдаршсан байна. “Эрдэнийн сан Субашид” нь монголын

¹ **Сажа Бандид Гунгаажалцан** нь (1182–1251) Төвөдийн Зан мужийн хүн, Сажа (Цайвар шороот) нь түүний уг нутгийн нэр, Бандид гэдэг нь Энэтхэг оронд очиж хүртсэн эрдмийн цол юм. Энэтхэгт бүх эрдэм ухааныг таван зүйлд хуваадаг байсан ба таван ухаанд мэргэжсэн хүнд Бандид цолыг олгодог байжээ. Гунгаажалцан (Дарма дүваза буюу Баясгалант ялгуусан гэмдэг) нь түүний жинхэнэ нэр боловч Сажа Бандид гэж ихэд алдаршсан. Сажа Бандидыг XIII зууны дундуур үед Өгөөдэйн хүү Годан Хөх нуурт нутаглаж байхдаа анх залж авчирсан байна. Тэгэхдээ Сажа Бандид ач хүүгээ дагуулж ирсэн, тэр нь алдарт Пагба лам болно. Сажа Бандид, монгол үсгийг зохиосон домог байдаг.



Зураг 1. Эрдэнийн сан Субашидын хятад модон барын хувилбар. МҮНС. Дансны дугаар М 0056751-001. Модон бар. 38 х. Хуудасны хэмжээ 37,0×8,0 см. Бичвэрийн хэмжээ 32,0×6,0 см.

уран зохиолын баримт хэрэглэгдэхүүн болж, монголчуудын оюун сэтгэлгээнд чухал нөлөө үзүүлсэн. Үүний тод илрэл нь “Оюун түлхүүр”, “Мэргэн гэгээний сургаал”, “Цаасан шувуу” зэрэг зохиолууд болно. Тийм ч учраас ард түмний дунд “Уйлъя гэвэл Ушаандрыг, суръя гэвэл Субашидыг” гэсэн зүйр үг [Дамдинсүрэн, 1999. Х. 16] гарсан байна. Иймээс “Эрдэнийн сан Субашид”-ыг ардын аман зохиолын үлгэр зэрэг төрөл зүйлүүдийн нэгэн адилаар монголчуудын соёл, өв уламжлалыг судлахад ашиглах боломжтой гэж үзэж байна.

Субашид 9 бүлэгтэй бөгөөд бүлгийн гарчиг нь:

1. Мэргэн цэцнийг танихын аймаг
2. Дээд ихсийг танихын аймаг
3. Муу тэнэгүүдийг танихын аймаг
4. Сайн муу хоёрыг нийлүүлэн танихын аймаг
5. Сайн муу явдлыг танихын аймаг
6. Ер юмны чухам голыг танихын аймаг
7. Ер зохисгүй юмыг танихын аймаг
8. Ер явах явдал үйлийг танихын аймаг
9. Номоор явахын ёсыг танихын аймаг

Субашидыг XIV зуунд тарнич тойн Сономгарав, XVIII зуунд Урад хошууны мэргэн гэгээн Дамбажалсан, 1778 онд Цахар гэвш Лувсанчүлтэм, XIX зууны сүүл үед Буриадын Агын дацангийн ширээт лам Лувсанринчен буюу Сумади Радна гээд үе үеийн бичгийн мэргэд төвөд хэлнээс орчуулсаар ирсэн байна.

Мөн нэрт эрдэмтэн Ц. Дамдинсүрэн Субашидыг Цахар гэвш Лувсанчүлтэмийн орчуулга

тайлбарын хамт эмхэтгэн хэвлүүлж байсан бөгөөд тус номондоо 1206 оноос урьд дөрвөлжин үсгийг өргөн хэрэглэж байх үед дөрвөлжин үсгээр Субашидыг хэвлүүлж байсан талаарх баримтыг [Дамдинсүрэн, 1999. Х. 14] дурджээ.

Энэ номын 3 дугаар бүлгийн “Муу тэнэгүүдийг танихын аймаг”-т дараах сургаал бий. Тэнд:

Ашид хүний хүчээр явсан муу хүн

Алсдаа аргагүй нэг доройтох болъюу.

Адилтгавал, хоёр галуунд дамнуулсан яст мэлхий

Айлын дэргэд унаж хоцорсон үлгэр мэт хэмээгээд, энэхүү сургаалын утгыг үлгэрээр тайлбарласан байна. Үүнд,

“Нэгэн нуурт хоёр галуу ба нэг яст мэлхий байснаас ган болоод нуур ширгэсэнд хоёр галуу өөр усанд одохыг завдахад, яст мэлхий өгүүлрүүн: “Та нар усанд одох бол намайг аваачигтун!” хэмээхэд, галуу өгүүлрүүн: “Чи үгэнд дуртай тул үл аваачна!” хэмээсэнд мэлхий: “Би юм бүү өгүүлсүгэй.” хэмээв.

Түүнээс явах цагт нэгэн өчүүхэн модны дундаас мэлхий зуугаад хоёр үзүүрээс нь хоёр галуу зууж нисээд явсаар нэгэн айлын дээгүүр гарахад олон хүүхэд үзээд, “Ай, хоёр галуу нэгэн мэлхийг дамнан явна.” гэхийг мэлхий сонсоод “Намайг шувуу аваачих биш, би өөрөө нисэж явна” гэж хэлэхээр дуугартал модоо алдан, хөсөр унасан гэдэг.” [Даминсүрэн, 1999. Х. 144] гэж тайлбарлажээ.



Зураг 2. Дээрх үлгэрийн цахим хувилбарууд.

Энэ үлгэр нь Ази, Европ зэрэг олон газар ардын үлгэр болтлоо дэлгэрсэн бөгөөд “Хоёр галуу, нэг мэлхий”, “Мэргэн галуу, тэнэг мэлхий”, “Галуу, мэлхий хоёр”, “Онгироо мэлхий” зэрэг олон янзын нэрээр ард олны дунд тархжээ. Сүүлийн үед техник технологийн хөгжил дэвшлийг даган, хүүхэлдэйн кино, видео бичлэг хийж, хүүхэд багачуудад таниулж байна.

Монгол ардын аман зохиолын нэг төрөл болох үлгэр нь олон зууны туршид эрт дээр үеэс эдүгээ хүртэл уламжлагдан ирэхдээ амаас ам дамжин улам боловсронгуй болсоор иржээ. Яваандаа тэдгээрийг тэмдэглэх болж, аман болон бичгийн хэлбэрээр уламжлагдан ирсэн бөгөөд бид үлгэрээс

*Үүл үүлийн хөвөөнд
Одод хяраалах шөнөөр
Үлгэрт нөмрөгсөн шинэ хэвнэг
Үзгээрээ эсгэж зүүдэллээ
Харваж байгаа сүүлт одны
Хайчин гэрлээр мэтгээ хуучрааж
Халхгар өргөн үлгэрийн хэвнэгийг
Ханзалж суугаад зүүдэллээ...*

Нутгийнхаа нүдэн нуурны
Намаг довыг бараадсан
Сар хөвсөн усанд нь
Одтой хөөцөлдөн сэлсэн
Сөөм газар дэвхрээд
Онгирч өөрийгөө магтсан
Нуурын замагны толбо
Нуруун дээр минь мөнхөрсөн
Нугын жаахан мэлхий байх юм би
Хаврын дунд сард
Нуурын энгэр ярж буусан
Хуурын дуу шиг нургисан
Холын хоёр бор галуу
Эвлэн дуудан далиа дэлж
Эгшиг цацан уруу татаж
Эндээ чи өглөөд яахав!
Энэ дэлхийгээр хамт нисье!
Бөх нь аргагүй саваа ол!
Бид хоёр үзүүрээс нь зууя!
Чи дундаас нь үмх!
Чимээгүй явахыг л гуйя! гэлээ.
Ярих эрхгүй нисээд
Яах ч юм билээ! гэж би бодлоо.
Явж явж хаана очиж

амьдралын жам ёс, хууль, улс үндэстний соёл, зан заншлын тухай төрөл бүрийн мэдлэг олж авдаг. Өөрөөр хэлбэл, танин мэдэхээс гадна биднийг төлөвшүүлж, хүмүүжүүлж байдаг.

Тэрчлэн хүмүүсийн хоорондын харилцааны үндэс, ёс суртахууны сайн мууг ялгаж ойлгох, сайн чанаруудыг эзэмших арга замыг зааж өгдөг. Тэсвэр тэвчээр түүнд хүрэх арга замыг заахаас гадна бүтээлч байдал, төсөөлөл, сэтгэлийн мэдрэмжийг хөгжүүлж, байгаль орчны тухай анхдагч ойлголт, мэдлэгийг өгдөг билээ.

Одоо үлгэрийн өгүүлэмжээр бичсэн Б. Лхагвасүрэнгийн “Үлгэр нөмрөгсөн хэвнэг” шүлгийг харъя.

Няц унадаг бол доо ч гэж айлаа.
Өдөр хоног дараалан бодож
Өдгүй төрснийхөө хорыг
Баярлуулъя гэж шийдлээ.
Өвөөгийнхөө таягийг галуунд зуулгаж
Бахдам өндөр нисэж гарлаа
Уул гэдэг хураасан аргал
Улс амьтан үймсэн шоргоолж
Гэр, тэнгэрийн дүлий шиг жаахан
Нуур, аягатай ус шиг бяцхан...
Тэнгэрт мэлхий ингэж нисдэг ээ! гэсэн шуугиан
Тодхон гэж жигтэйхэн...
Эх газрын магтуунд чих дүнгэнэнэ.
Эрээн үүлс хажуугаар өнгөрнө
Энэ арга билгийг хэн олов оо! гэх шагшаан
Элгэн доороос цоргин хөөрөгдөнө
Хөөрүү сэтгэл минь тэсэж чадалгүй
Би! гэж хэлтэл
Хөх тэнгэрийн гүнээс
Шидсэн чулуу шиг уналаа
Газарт хүрэхийн алдад аз болж

Гайтай зүүднээс сэрж амарлаа
 Үүл үүлийн хөвөөнд
 Одод хяраалах шөнөөр
 Үлгэрт өмсгөх шинэ хэвнэг
 Үзгээрээ эсгээж зүүдэллээ

Яруу найрагч шүлэгтээ:

Нутгийнхаа нүдэн нуурны
 Намаг довыг бараадсан
 Нуурын замагны толбо
 Нуруун дээр минь мөнхөрсөн
 Нугын жаахан мэлхий байх юм би
 хэмээн,

өөрийгөө мэлхий болгон зүүдлээд, тэр нуу-
 рын хоёр бор галуу, амандаа саваа зууж, сава-
 анаасаа мэлхийг үмхүүлэн, өндөрт нисэж буй
 тухай, “Энэ аргыг хэн олсон бол?” хэмээн олны
 шагшин ярихыг сонсоод, хөөрүү сэтгэлдээ “Би”
 хэмээн хэлтэл:

*Хөх тэнгэрийн гүнээс
 Шидсэн чулуу шиг уналаа
 Газар хүрэхийн алдад*

Гайтай зүүднээс сэрж амарлаа гэж эртний
 сургаалын тайлбар үлгэрийн өгүүлэмжийг
 ашиглан, өөрийгөө буюу хүнийг мэлхийгээр
 дүрсэлжээ. Өөрөөр хэлбэл, *үлгэрт нөмрөгсөн
 шинэ хэвнэг үзгээрээ эсгээж, хавж* (хол хол нэвт
 оёх) [Монгол хэлний зөв бичих дүрмийн жу-
 рамласан толь 2018. Х 351] *суугаагаар* дүрсэ-
 лсэн байна. Ингэж зохиолчийн хөдөлмөрийн
 нарийн чимхлүүр ажлыг, монгол эмэгтэйн уран
 нарийн үйл мэтгэх урлагтай зүйрлэн өгүүлсэн
 нь сонирхолтой өгүүлэмж юм.

Тэрээр шүлэгтээ мэлхий болон галууг хүн-
 шүүлэн дүрслэхдээ “Зохист аялгуун толь” дахь
 үлгэрийн дүрст чимгийг ашигласан байна. III.
 Гаадан багшийн “Зохист аялгуун толийн тайл-
 бар”-т энэ тухай «Эрхэм эгэл хоёрыг адилтган,
 тэгэхдээ дүрслэн өгүүлэх аргаар гаргахыг үлгэ-
 рийн дүрст чимэг гэнэ» [Гаадан, 1982. Х. 125]
 гэсэн буй.

Иймд “хүн” гэх эрхэм нэрийг эгэл нэг мэл-
 хийтэй жишиж, үлгэрийн өгүүлэмжээр илэр-
 хийлсэн нь уг дүрст чимэгт тохирч байна.

Ер нь Б. Лхагвасүрэнгийн уран бүтээлийг
 ажиглахад, МЭ-ний VII-VIII зууны үеийн Энэ-
 тхэгийн яруу найргийн онол Дандийн “Зохист

Харваж байгаа сүүлт одонд
 Хадган хөх бэх сүвлэж
 Халхгар өргөн үлгэрийн хэвнэгийг
 Хавж суугаад зүүдэллээ
 [Лхагвасүрэн 2006. Х. 84]

аялгуун толь”-ийн 2 дугаар бүлэг дэх “Түтгэх
 чимэг”-ийг ашигласан нь түгээмэл байдаг.

Энэ нь үзэгдлийн мөн чанар, учир байдлыг
 уран сэтгэмжээр зориуд гажуудуулан гүтгэж
 өгүүлэх уран найруулгын арга бөгөөд үүнийг
 ашиглан, амьгүйг амьгүйчлэн дүрсэлсэн нь
 өвөрмөц ажээ.

Шүлгийн эхлэл болон төгсгөл хэсгийг мон-
 гол шүлгийн уламжлалт холбоц болох хаших
 холбоцоор холбохдоо шадаар бус бадгаар ха-
 шин холбож, төгсгөлийн хэсэгт утгыг гүнзгий-
 рүүлэн, үлгэрт өмсгөх шинэ хэвнэг үзгээрээ
 эсгэн, хавж суугаагаар дүрсэлсэн нь өвөрмөц
 зохиомжтой болжээ.

Тэрчлэн монгол шүлэгт ихээхэн хэрэглэгд-
 дэг нэг арга болох тэгш хэмийн зарчмаар эхэлж,
 төгсгөсөн нь шүлгийн хэмнэлийг жигдрүүлж,
 утгын гүнзгийрлийг илэрхийлсэн байна.

Монгол хэлний өгүүлбэр зүйн тогтсон да-
 рааллыг зориуд өөрчлөн, “Зориудын дараа-
 лал”-ыг зарим шадад хэрэглэсэн нь шүлгийг
 уянгалаг болгожээ. Жишээ нь:

*Гэр, тэнгэрийн дүлий шиг жаахан
 Нуур, аягатай ус шиг бяцхан* гэх мэт.

Тэрчлэн монгол шүлэглэх ёсонд чухал он-
 цлогтой тэгш хэмийн зарчмыг эхлэл болон
 төгсгөл хэсэгт хэрэглэсэн нь шүлгийг айзмын
 хувьд жигд, уянгалаг болгосон байна.

Үг сонголтын хувьд өвөрмөц. Тэрбээр адил-
 тгал, утга шилжүүлэх, төлөөлүүлэх, аман яри-
 аны хэллэгийг хэрэглэжээ. Тухайлбал: “Нүдэн
 нуур, сар хөвсөн ус, одтой хөөцөлдөн сэлэх, хав-
 рын дунд сар, нуурын энгэр ярж буух, хуурын дуу
 шиг нургисан, уул гэдэг хураасан аргал, улс амь-

тан үймсэн шоргоолж, гэр- тэнгэрийн дүлий шиг жаахан, нуур-аягатай ус шиг бяцхан” гэх мэт үг хэллэгээр монголчуудын үндэсний сэтгэлгээ, зан заншил, байгаль хүн хоёрын хүйн холбоо, соёлын онцлогийг нарийн тодруулан гаргаж чадсан байна.

Үүний зэрэгцээ үлгэрт гарч буй галуу болон мэлхийн дүрийг амьдчилан, ёс суртахууны үнэт зүйлийг хөндөснөөрөө үнэ цэнтэй. Ёс суртахууны эерэг болон сөрөг үнэлгээг уншигчдаар гаргуулах, багш сурган хүмүүжүүлэгчид өсвөр насныхантай ярилцах, үнэлэлт дүгнэлт өгөхөд энэ шүлэг жишээ болно.

Дүгнэлт

Ардын уран зохиолч Б. Лхагвасүрэнгийн шүлгүүд нь чөлөөт хүүрнэл, түүнд шингэсэн бодол бясалгал, харилцан яриа, зүүд, зөн совин, өчил, домгийн сэтгэлгээний элемент зэрэг

зохиомжийн төрлүүдийг хамруулсан нийлэг бүтцээрээ сонирхолтой байдаг. Үүний нэг нь үлгэрийн өгүүлэмжийг зүүд хэлбэрт оруулан дүрсэлсэн дээрх шүлэг бөгөөд уламжлалыг шинэчлэснээрээ өвөрмөц.

Зохиолч “Үлгэр нөмрөгсөн хэвнэг” шүлгээрээ хүмүүсийн хоорондын харилцааны үндэс, ёс суртахууны сайн мууг ялгаж ойлгох, сайн чанаруудыг эзэмших арга зам, тэсвэр тэвчээр түүнд хүрэх арга замыг заахаас гадна бүтээлч байдал, төсөөлөл, сэтгэлийн мэдрэмжийг хөгжүүлэхийн зэрэгцээ байгаль экологийн тухай ойлголтыг өсвөр үеийнхэнд таниулж байгаа нь чухал.

Өөрөөр хэлбэл, ардын аман зохиол, үлгэрийн өгүүлэмжийг ашиглан, зүүд хэлбэрээр зохиомжилж, хүүхэд багачуудад ёс суртахууны эерэг ойлголтыг таниулсан нь их ач холбогдолтой юм.

НОМ ЗҮЙ

Бигэрмаа 2016: Бигэрмаа Р. XX зууны яруу найргийн шинэтгэл шинж. Улаанбаатар, 2016.

Bigermaa R. XX зууны яруу найргийн шинэтгэл шинж [Poetic innovation of the XX century]. Ulaanbaatar, 2016.

Лхагвасүрэн, 2006: Лхагвасүрэн Р. Бүрэн түүвэр. 1-р боть. Бээжин, 2006.

Lkhagvasuren R. Buren tuuver. I bot' [Full collection of samples]. Beijing, 2006.

Уэллек, Уоррен 2015: Уэллек. Р., Уоррен. О Уран зохиолын онол. Улаанбаатар, 2015.

Uellek R., Uorren O. Uran zokhiolyn onol [Theory of literature]. Ulaanbaatar, 2015.

Галбаатар 2012: Галбаатар. Д Уран зохиолын нэр томъёоны нэвтэрхий толь. Улаанбаатар, 2012.

Gaalbaatar D. Uran zokhiolyn ner tomiony navterkhiy toil [Encyclopedia of literary terms]. Ulaanbaatar, 2012.

Гаадан 1982: Гаадан. Ш Зохист аялгуун толийн тайлбар. Улаанбаатар, 1982.

Gaadan Sh. Zokhist ayalguuny toliin tailbar [Explanation to the dictionary of melodic correspondences]. Ulaanbaatar, 1982.

Дамдинсүрэн, 1999: Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын тойм. Улаанбаатар, 1999.

Damdinsuren Ts. Mongolyn uran zokhiolyn toim [Samples of Mongolian literature]. Ulaanbaatar, 1999.

Монгол толь, 2018: Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь. Улаанбаатар, 2018.

Mongol khelny suv bihihkh durmiin zhuramlasan toli [Spelling dictionary of the Mongolian language]. Ulaanbaatar, 2018.

FOLKLORE TRADITIONS OF THE POETRY OF THE NATIONAL WRITER B. LHAGVASUREN (on the example of the poem “Cape wrapped in a fairy tale”)

Ragchaa BIGERMAA

Mongolian University of Science and Technology

One of the most important cultural values of the Mongolian people is folklore. A large number of folk songs, fairy tales, legends, games have reached our time. The honored writer B. Lhagvasuren occupies a leading place in the development of modern Mongolian literature. He wrote several children's poems using folklore motifs. This article analyzes the poem “Cape wrapped in a fairy tale”, an attempt is made to reveal the artistic features of the work, which reflects the unique features of the mentality, culture, traditional thinking, principles of morality of the Mongols. The article draws an analogy of the behavioral motivations of modern heroes with the basic attitudes of the actions of the characters of Mongolian folklore. The article touches upon the problems of tradition and innovation of modern Mongolian poetry, the mental connections of the poet of the XX century with the poetry of ancient times. Attention is paid to the genre of the Mongolian fairy tale, understood by the author of the article as a type of oral literature, the purpose of which is to illustrate an example expressed with the help of a conditional representation of reality, the aspirations of the people. The article attempts to understand the innovative artistic methods and techniques used by B. Lhagvasuren to attract fairy-tale material into his works.

Key words: Mongolian folklore, tales, traditions, innovation, poetry.

About the author: **Ragchaa BIGERMAA**, PhD., Department of Asian Studies, School of Foreign language, Mongolian University of Science and Technology (Ulaanbaatar, Mongolia) (bigermaa@must.edu.mn). ORCID 0000-0003-2033-5441.